

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Хөвсгөл дулааны станц” ТӨХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан.

Аудитын код: ХӨА-2024/01/НА-СТА-ТӨА

Цахим хуудас:
www.audit.mn
Хөвсгөл аймаг
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089116 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn
Аудитор: Л.Мандахнаран
Утас: 92119277 Цахим хаяг: Mandakhnaranl@audit.gov.mn
Аудитор: Б.Ариунтуяа
Утас: 99038632 Цахим хаяг: Ariuntuyab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.08.15 № 01/246
танай _____ -ны № _____ -т

“ХӨВСГӨЛ ДУЛААНЫ СТАНЦ”
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.ЦАНЛИГРЭНЧИН ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хөвсгөл дулааны станц” ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Хөвсгөл дулааны станц” ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд станцын их засварын ажилд 778.8 сая төгрөг, техник зохион байгуулалтын зардалд 114.3 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 339.5 сая төгрөг нийт 1,232.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг хийсэн бөгөөд 2.7 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Аудитын гол асуудал

Баяр ёслолын үйл ажиллагаанд зориулж нийт 8.0 сая төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан, 30.4 сая төгрөгийн Хувь хүний орлогын албан татварын авлага, 0.2 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлага үүсгэсэн, Санхүүгийн үйл ажиллагаанд аккрузал суурийг бүрэн мөрдөж ажиллаагүй, гүйцэтгэх захирлын эрх үүрэгт нийцээгүй журам боловсруулж мөрдөн ажилласан зэрэг зөрчил илэрсэн.

Бусад асуудлын хэсэг

“Хөвсгөл Дулааны Станц” ТӨХК нь 2014 онд KB11.63-115/70 BTM маркийн ул ширэм дээр үеэр шатаах технологитой цагт 10 Гкал/ц дулааны эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалтай 3 ширхэг зуухтай 30 Гкал/ц суурилагдсан хүчин чадалтай бөгөөд 2024 оны байдлаар нийт 17-н дулаан дамжуулах төвөөр дамжуулан 29.7 Гкал/ц тооцоот ачаалалтай байна.

“Хөвсгөл дулааны станц” ТӨХК нь эрчим хүчний 3 зуухыг аваарын нөөцгүйгээр бүрэн хүчин чадлаар нь ажиллуулсан, нүүрсний чанар муудсан зэргээс шалтгаалан 2023-2024 оны өвөлжилт хүндэрч, халаалт дулааны чанар стандарт алдагдаж, халаалтын температур муудахад нөлөөлсөн байна.

6724040595

Иймд эрх бүхий байгууллагад хандаж Дулааны станцын тоног төхөөрөмж хүчин чадлыг нэмэгдүүлэх, аваарын нөөц үүсгэх тал дээр онцгой анхаарал хандуулах шаардлагатай байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Мөрийн дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	229,086,120.66	93,945,646.05
1.1.2	Дансны авлага	200,226,631.93	791,552,439.46
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	0.00	87,883,722.77
1.1.6	Бараа материал	829,139,762.09	812,853,961.42
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,258,452,514.68	1,786,235,769.70
1.2.1	Үндсэн хөрөнгө	30,814,546,575.20	30,704,091,150.50
1.2.2	Биет бус хөрөнгө	502,434,785.70	498,482,536.53
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	61,263,570.05	82,395,809.70
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	31,378,244,930.95	31,284,969,496.73
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	32,636,697,445.63	33,071,205,266.43
2.1.1.1	Дансны өглөг	167,948,805.14	484,539,334.84
2.1.1.3	Татварын өр	75,868,878.56	0.00
2.1.1.4	НДШ-ийн өглөг	476,202.28	0.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	20,822,478.08	11,994,870.25
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	265,116,364.06	496,534,205.09
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	61,263,570.05	82,395,809.70
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	61,263,570.05	82,395,809.70
2.2	Өр төлбөрийн нийт дүн	326,379,934.11	578,930,014.79
2.3.1	Төрийн өмч	33,981,526,313.42	33,981,526,313.42
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,155,701,953.17	3,334,309,479.71
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	462,450,000.00	462,450,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-5,289,360,755.08	-5,286,010,541.50
2.3.11	Эздийн өмчийн дүн	32,310,317,511.51	32,492,275,251.63
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	32,636,697,445.62	33,071,205,266.42

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	6,994,479,945.00	8,230,237,513.89
2	Борлуулалтын өртөг	6,935,426,617.47	8,159,549,279.34
3	Нийт ашиг (алдагдал)	59,053,327.53	70,688,234.55
4	Түрээсийн орлого	0.00	0.00
5	Хүүгийн орлого	0.00	0.00
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	677,632,911.41	803,192,718.38
9	Борлуулалт, маркетингийн зардал	288,209,619.28	377,097,422.84
10	Ерөнхий ба удирдлагын зардал	201,093,364.81	227,901,828.81
11	Санхүүгийн зардал	22,492,459.48	0.00
12	Бусад зардал	224,026,188.65	266,135,067.32
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	1,363,636.37	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	2,228,243.09	2,746,633.96
19	Орлогын татварын зардал	3,000,000.00	274,663.40
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-771,756.91	2,471,970.56
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0.00	0.00

"Хөвсгөл дулааны станц" ТӨХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	-771,756.91	2,471,970.56
25	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	33,981,526,313.42	3,155,701,953.17	462,450,000.00	-5,356,966,552.77	32,242,711,713.82
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	68,303,526.20	68,303,526.20
Залруулсан үлдэгдэл	33,981,526,313.42	3,155,701,953.17	462,450,000.00	-5,288,663,026.57	32,311,015,240.02
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-771,756.91	-771,756.91
2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	33,981,526,313.42	3,155,701,953.17	462,450,000.00	-5,289,360,755.08	32,310,317,511.51
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	878,243.02	878,243.02
Залруулсан үлдэгдэл	33,981,526,313.42	3,155,701,953.17	462,450,000.00	-5,288,482,512.06	32,311,195,754.53
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	2,471,970.56	2,471,970.56
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	178,607,526.54	0.00	0.00	178,607,526.54
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	33,981,526,313.42	3,334,309,479.71	462,450,000.00	-5,286,010,541.50	32,492,275,251.63

"Хөвсгөл дулааны станц" ТӨХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	8,447,821,328.03	9,124,478,442.22
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	8,068,314,231.36	8,418,645,490.71
1.1.4	Буцаан авсан албан татвар	2,960,520.00	4,546,996.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	376,546,576.67	701,285,955.51
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	7,478,624,269.27	8,268,235,615.83
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,539,640,790.26	1,828,807,126.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	546,996,803.98	651,227,982.51
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	2,237,322,411.58	2,098,033,015.51
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	646,823,321.00	827,781,192.11
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,722,189,968.14	1,985,491,575.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	656,656,908.68	749,465,515.04
1.2.9	Бусад мөнгөн зарлага	128,994,065.63	127,429,209.66
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	969,197,058.76	856,242,826.39
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,163,636.37	0.00
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	1,363,636.37	0.00
2.1.5	Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	2,800,000.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	361,671,345.80	991,383,301.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	351,421,545.80	991,383,301.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	10,249,800.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-357,507,709.43	-991,383,301.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	110,000,000.00	0.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	110,000,000.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	510,000,000.00	0.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	510,000,000.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-400,000,000.00	0.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	211,689,349.33	-135,140,474.61
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	17,396,771.33	229,086,120.66
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	229,086,120.66	93,945,646.05

"Хөвсгөл дулааны станц" ТӨХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Техник, эдийн засгийн үзүүлэлтүүд		Хэмжих нэгж	2022 оны Гүйцэтгэл	2023 он		Харьцуулалт	
					Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2022 оны гүйцэтгэл ээс	2023 оны төлөвлөгөө өнөөс
					1	2	3	5
1	Үйлдвэрлэх	ДЭХ	мян.Гкал	86.7	85.5	82.9	-3.7	-2.6
	Дотоод хэрэгцээний дулаан эрчим хүчний зарцуулалт	хувиар	хувь	1.8	1.9	1.9	0.1	0.1
		биетээр	мян.Гкал	1.6	1.6	1.6	0.0	-
	Түгээх	ДЭХ	мян.Гкал	85.1	83.9	81.4	-3.7	-2.6
2	Нийт орлого		сая.төг	7,673.5	8,850.2	9,033.4	1,360.0	183.2
	Үүнээс:	Борлуулалтын орлого	сая.төг	6,994.5	8,119.2	8,230.2	1,235.8	111.0
		Үйл ажиллагааны бус орлого	сая.төг	360.8	167.4	239.6	-121.3	72.2
		Татаас санхүүжилтийн орлого	сая.төг	318.2	563.6	563.6	245.5	-
3	Нийт зардал		сая.төг	7,674.2	8,850.2	9,030.7	1,356.4	180.5
	Үүнээс:	Үйл ажиллагааны зардал	сая.төг	7,618.0	8,842.6	8,990.7	1,372.8	148.1
		Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	56.3	7.6	40.0	-16.3	32.4
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/		сая.төг	0.8	-	2.7	3.5	2.7
5	Татварын дараах ашиг /алдагдал/		сая.төг	0.8	-	2.5	3.2	2.5
6	Борлуулалтын орлогын 1 төг-т ногдох зардал		төг	1	1	1	-	-
7	Нийт авлага		сая.төг	200.2	1,332.5	879.4	679.2	-453.0
8	Нийт өглөг		сая.төг	326.4	1,061.9	578.9	252.6	-483.0
9	Нийт ажиллагсад		тоо	133	135	133	-	-2
10	Нийт цалингийн сан		сая.төг	1,957.9	2,383.9	2,333.3	375.4	-50.6
11	Жишмэл түлшний хувийн зарцуулалт		кг/Гкал	213.3	204.1	211.7	-1.6	7.6
12			сая.төг	349.2	1,277.8	1,232.6	883.4	-45.3

Дараагийн аудитаар анхаарах асуудал

- “Хөвсгөл Дулааны Станц” ТӨХК нь 2014 онд KB11.63-115/70 BTM маркийн ул ширэм дээр үеэр шатаах технологитой цагт 10 Гкал/ц дулааны эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалтай 3 ширхэг зуухтай 30 Гкал/ц суурилагдсан хүчин чадалтай бөгөөд 2024 оны байдлаар нийт 17-н дулаан дамжуулах төвөөр дамжуулан 29.7 Гкал/ц тооцоот ачаалалтай байна. Станцын эрчим хүчний 3 зуухыг аваарын нөөцгүйгээр бүрэн хүчин чадлаар нь ажиллуулж байна.

Иймд эрх бүхий байгууллагаас Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн Хөрөнгө оруулалт, техник тоног төхөөрөмжийн шинэчлэл, өргөтгөлийн ажлыг гүйцэтгэх төсөв санхүүгийн асуудлыг шийдвэрлэх асуудлыг дараагийн шатны аудитаар хянан үзэх.

- Эрчим хүчний салбарын 2023-2024 оны хамтын хэлэлцээр нь хууль тогтоомжид бүрэн нийцэхгүй байгаа бөгөөд уг хэлэлцээрт үндэслэн Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал нь Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн дэргэдэх үйлдвэрчний эвлэлийн хороотой 2022-2024 онд мөрдөн ажиллах хамтын гэрээ байгуулсан байна. Тус хамтын гэрээний 6.4, 6.25, 6.27, 6.28, 6.29 дахь заалтууд нь холбогдох хууль тогтоомж болон Эрчим хүчний сайдын 2016 оны 97 дугаар тушаалаар баталсан “Эрчим хүчний тэргүүний ажилтан” болон “Яамны жуух бичгээр шагнах журам”-ын нэгдүгээр хавсралын 5.3 дахь заалт, 4 дүгээр хавсралтын 5 дахь заалтуудтай нийцээгүй бөгөөд Хөдөлмөрийн тухай хуулийн 82 дугаар зүйлд заасан тэтгэмж олгох доод хэмжээг 4-өөс 6 дахин нэмэгдүүлэн тооцсон байна.

Иймд Эрчим хүчний салбарын хамтын хэлэлцээр, тус байгууллагын хамтын гэрээг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан эсэх асуудлыг дараагийн аудитаар анхаарал хандуулах шаардлагатай байна.

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 221.6 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 8.0 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 2.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах, таслан зогсоох 2 албан шаардлага хүргүүлж, 211.1 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

Аудитаар 8.0 сая төгрөгийн материаллаг зөрчил илэрсэн бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг түвшнээс хэтрээгүй тул өөрчлөлтгүй санал дүгнэлт өгсөн болно.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар илэрсэн зөрчилд 8.0 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон. Үүнд:

- Баяр ёслолын үйл ажиллагаанд зориулж уран сайхны тоглолтын үйлчилгээ авахад 1.5 сая төгрөг, хүлээн авалтын хоолны зардалд 3.0 төгрөг, тавгийн чихэр ус ундааны зардалд 1.3 сая төгрөг, бэлэг дурсгалын зүйлд 2.1 сая төгрөг, нийт 8.0 төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан.
- Ахмадын баярын үйл ажиллагаанд 2.3 сая төгрөгийг зарцуулснаас 0.1 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Дээрх зөрчлүүд нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3. “үр ашигтай байх” 12 дугаар зүйлийн 12.1.4. “хуулиар зөвшөөрөөгүй бусад” 15 дугаар зүйлийн 15.1.5. “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах”, 15 дугаар зүйлийн 15.1.7. “байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах”-ыг хориглоно” гэсэн заалтуудтай нийцээгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2 Албан шаардлага

- “Хөвсгөл дулааны станц” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2022 оны А/48 дугаар тушаалаар Нэмэлт орлогыг зарцуулах журмыг баталсан байна. Дээрх журам нь Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн дүрмийн ТУЗ-ийн эрх, үүргийн хэсгийн 9.3.9 дэх

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

"компанийн гүйцэтгэх удирдлагатай байгуулах контрактын нөхцөл, түүнд олгох цалин, шагнал, урамшуулал, өмч хөрөнгийг захиран зарцуулах эрх, хариуцлагын хэмжээг тогтоох контракт байгуулах" заалттай нийцээгүй, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул "Нэмэлт орлого зарцуулах журам"-ыг хүчингүй болгох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

- Эрчим хүчний болон бусад салбарын тэргүүний ажилтан, төрийн дээд одон медалиар шагнагдсан 26 ажилтанд 2.9 сая төгрөгийн шагнал олгосон байна. Үүнээс өмнөх онуудад шагналаа авсан 19 ажилтанд 2.5 төгрөгийн тэмдэгтийн мөнгөн шагнал олгосон байна. Энэ нь Эрчим хүчний сайдын 2016 оны 97 дугаар тушаалаар баталсан "Эрчим хүчний тэргүүний ажилтан" болон "яамны жуух бичгээр шагнах журам"-ын нэгдүгээр хавсралын 5.3 "Эрчим хүчний тэргүүний ажилтан хүндэт тэмдгээр шагнахад ЗГ-ын 2012 оны 142 дугаар тогтоолыг үндэслэн 100,000 төгрөг, яамны жуух бичгээр шагнахад ЗГ-ын 1997 оны 53 дугаар тогтоолыг үндэслэн 10,000 төгрөгийн дагалдах мөнгөн шагналыг тухай ажилтныг шагнуулахаар тодорхойлсон үндсэн байгууллага нэг удаа олгоно", 4 дүгээр хавсралтын 5 "Яамны жуух бичгээр шагнахад 10,000 төгрөгийн мөнгөн шагналыг нэг удаа олгоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байгаа тул албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: ХХОАТ-ын авлага 30.4 сая төгрөг, Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 0.2 сая төгрөг нийт 30.6 сая төгрөгийн авлага үүсгэсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 8/ "өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5. "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудтай нийцээгүй бөгөөд Эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж: Дансны авлагыг барагдуулж, төлбөр тооцоо, ажил, гүйлгээг гаргахаас өмнө хянан, баталгаажуулж авлага үүсгэхгүй ажиллах.

2. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Зорилтод түвшнийг 180.5 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн Захирал дараахь эрх, үүрэгтэй: 3/ "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэсэн заалттай нийцээгүй бөгөөд "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдэлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан зардлын зорилтот түвшнийг баримтлан зардлыг хэтрүүлэхгүй байх.

3. Хамтын гэрээтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Хамтын гэрээний 6.4, 6.25, 6.27, 6.28, 6.29 дахь заалтууд нь холбогдох хууль тогтоомж болон Эрчим хүчний сайдын 2016 оны 97 дугаар тушаалаар баталсан "Эрчим хүчний тэргүүний ажилтан" болон "яамны жуух бичгээр шагнах журам"-ын нэгдүгээр хавсралын 5.3 дахь заалт, 4 дүгээр хавсралтын 5 дахь заалтуудтай нийцээгүй, Хөдөлмөрийн тухай хуулийн 82 дугаар зүйлд заасан тэтгэмж олгох доод хэмжээнээс 4-өөс 6 дахин нэмэгдүүлэн тооцсон байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хамтын гэрээнд өөрчлөлт оруулах.

4. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой асуудал.

"Хөвсгөл дулааны станц" ТӨХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

Илрүүлэлт: Санхүүгийн тайланг бэлтгэхдээ бараа материалыг бүрэн орлого авч зардал гаргаагүй шууд зардалд бүртгэсэн, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд аккруэл суурийг бүрэн мөрдөж ажиллаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1."Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 14 дүгээр зүйлийн 14.4.5."бүх орлого", 14.4.6."бүх зардал"-ыг заавал бүртгэнэ, НБББББ-ийн 1 дүгээр зүйлийн Нягтлан бодох бүртгэлийн зохион байгуулалттай тус тус нийцээгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: НББ-ийг хөтлөхдөө бүх орлого, зардлыг бүртгэж аккруэль суурийг бүрэн мөрдөж ажиллах

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Хүснэгт №-6. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Авлага үүсгэсэн	1	30,620.9					1	30,620.9
Зардлын зорилгод түвшнийг хэтрүүлсэн	1	180,453.0					1	180,453.0
Шинэ жилийн үйл ажиллагаанд зориулж зардал гаргасан	1	7,950.9	1	7,950.9				
Зориулалт бусаар зардал гаргасан	1	97.0	1	97.0				
Аккруэл суурийг бүрэн мөрдөж ажиллаагүй	1						1	
Эрчим хүчний болон бусад салбарын тэргүүний ажилтан, төрийн дээд одон медалиар шагнагдсан ажилчдад сар бүрээр тооцож шагнал олгосон.	1	2,452.0			1	2,452.0		
Дүн	6	221,574.0	2	8,048.1	1	2,452.0	3	211,073.8

Хүснэгт №-7. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Хамтын гэрээний 6.4, 6.25, 6.27, 6.28, 6.29 дахь заалтууд нь холбогдох хууль тогтоомжид нийцээгүй	1						1	
Гүйцэтгэх захирлын эрх үүрэгт нийцээгүй журам баталсан	1				1			
Дүн	2				1		1	